

ХОРШООНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЖУРАМ

Хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгө нь түүний үйл ажиллагааны санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болно.

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь мөнгөн хэлбэртэй байхын зэрэгцээ эд хөрөнгө (хөрөнгийн нэр, хэмжээ заах), хөдөлмөр оролцоо (ажлын байр, ажлын хэмжээ, хэлбэрийг заах) байж болно.

Эд хөрөнгийг хоршоонд хүлээн авахдаа комисс томилон(эсвэл хоршооны тэргүүлэгчид) үнэлгээ хийж, энэ талаар баримт үйлдэнэ. Хөрөнгө болон хөдөлмөр оролцоог үнэлэхдээ тухайн үеийн орон нутгийн ханшийг баримтална.

Гишүүнээр элсэхийг хүсэгч нь хувь хөрөнгөө бүрэн хэмжээгээр нийлүүлж, тэргүүлэгчдийн хурлаас гишүүнээр элсүүлэх шийдвэр гарснаар хоршооны гишүүн болно. Гишүүнчлэлийн хугацааг гишүүнээр элсэхийг хүссэн өргөдөл гаргасан өдрөөр тооцно.

Хувь нийлүүлсэн хөрөнгөө бүрэн бус буюу огт нийлүүлээгүй бол гишүүнээр элсүүлэхгүй. Гэхдээ гишүүн нь хувь нийлүүлсэн хөрөнгөө хөдөлмөр оролцоогоор бүрдүүлэх бол түүнтэй гэрээ хийж, хугацааг тохиролцох ба хувь нийлүүлсэн хөрөнгө бүрэн хэмжээгээр бүрдсэн тохиолдолд гишүүнээр бүртгэн гишүүнчлэлийн хугацааг тооцно.

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь хоршооны үйл ажиллагааны орлогоос ноогдол ашиг хүртэх үндэслэл болно.

Гишүүн нь хувь нийлүүлсэн хөрөнгийг нэгэнт эхэлсэн санхүүгийн жил дуусахаас (12 дугаар сарын 31-ээс) өмнө хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр буцаан авах боломжгүй. Мөн хувь нийлүүлсэн хөрөнгөө бусадтай харилцах харилцаанд баталгаа болгон ашиглаж болохгүй.

Хоршооны гишүүнээс гарсан, хасагдсан гишүүнд түүний хувь нийлүүлсэн хөрөнгийг санхүүгийн жил дууссанаас хойш 2 сард багтаан буцаан олгоно.

Хоршооны нэг гишүүний хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь ... төгрөг байна. Харин хоршооны нэг гишүүний хувь нийлүүлсэн хөрөнгийн дээд хэмжээ нь хоршооны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувиас (эсвэл ... төгрөгөөс) илүүгүй байна.

Дээрх хэмжээнд багтаан гишүүн нь хувь нийлүүлсэн хөрөнгөө хэзээ ч нэмэгдүүлж болно. Хоршооны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны зайлшгүй хэрэгцээ, шаардлагад үндэслэн хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг гагцхүү бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхэд:

- үйл ажиллагааны ашгийн ... хувийг хоршоондоо үлдээх(гишүүн хуваарилагдсан ноогдол ашгаасаа хувь нийлүүлсэн хөрөнгө),
- нийлүүлсэн бүтээгдэхүүний үнийн зөрүү, урамшууллаас хоршоондоо өөрийн нэр дээр бүртгүүлэн үлдээх,
- мөнгөн болон эд материалын хэлбэрээр нэмэлт хөрөнгө оруулах,
- хэрэгцээнд нийцсэн үнэт цаас нийлүүлэх,
- хөдөлмөр оролцоогоо үнэлүүлэх зэрэг хэлбэрийг ашиглах боломжтой.

Гишүүний хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орсон тухай бүрт түүнийг бүртгэлжүүлэн хоёр талаас харилцан баталгаажуулах үүргийг хоршооны дарга, тэргүүлэгчид хүлээнэ.